

ТАНИЛЦУУЛГА

*Журам батлах тухай Засгийн газрын
тогтоолын төсөл боловсруулсан тухай*

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэгт “Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүү, төсвийн, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална” гэж заасан.

Дээрх хуульд заасныг үндэслэн тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах “Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын болон журмын төсөл боловсруулав.

Энэхүү нөөц сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд (Засгийн газрын үнэт цаас, Монголбанкны үнэт цаас, арилжааны банкны хадгаламж, төрийн сангийн данс) байршуулах зохицуулалтыг хуульд тусгасан бөгөөд энэ шийдвэрийг даатгуулагчийн саналд үндэслэн нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөрөнгө оруулж, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх юм.

Түүнчлэн энэхүү хөрөнгийг 2030 оноос эхлэн өвлүүлэх эрхийг хуулиар бий болгосонтой холбоотойгоор энэ журамд даатгуулагчийн нөөц сангийн хөрөнгийг мэдээлэх, хэрхэн өвлүүлэх, өвлүүлэхтэй холбоотойгоор түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүний эрх ашгийг хэрхэн хангах талаарх нарийвчилсан зохицуулалтыг журмын төсөлд тусгалаа.

---oOo---